




ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ДҮН /хураангуй/



УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

АГУУЛГА

1. ХҮН АМ.....	3
2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА.....	5
3. ШАШИН	6
4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ.....	7
5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН	8
6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ	9
7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ	9
8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ.....	10
9.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ	13
10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ.....	14
11. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД	17
12. СУУЦНЫ НӨХЦӨЛ.....	18

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР	4
ХҮСНЭГТ 2. ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР 2000-2010, 2010-2020 ОН*	4
ХҮСНЭГТ 3. МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	6
ХҮСНЭГТ 4. ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН	9
ХҮСНЭГТ 5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН.....	16
ХҮСНЭГТ 6. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019, 2020 ОН	199


ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ТОО	3
ЗУРАГ 2. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР*	3
ЗУРАГ 3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН	5
ЗУРАГ 4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭИ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН	7
ЗУРАГ 5. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ХҮН АМД УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР.....	7
ЗУРАГ 6. ХҮН АМЫН НЯГТРАЛ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН.....	8
ЗУРАГ 7. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН	8
ЗУРАГ 8. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН	9
ЗУРАГ 9. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН	10
ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН.....	11
ЗУРАГ 11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРГЭЭР, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН	11
ЗУРАГ 12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН.....	12
ЗУРАГ 13. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020.....	13
ЗУРАГ 14. НИЙСЛЭЛИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ДҮҮРГЭЭР	13
ЗУРАГ 15. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН	14
ЗУРАГ 16. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН.....	14
ЗУРАГ 17. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН.....	15
ЗУРАГ 18. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРГЭЭР, 2020 ОН	16
ЗУРАГ 19. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ТОО, УЛСААР	17
ЗУРАГ 20. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН ДҮҮРГЭЭР, 2020 ОН	17
ЗУРАГ 21. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2020 ОН.....	18
ЗУРАГ 22. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН	18
ЗУРАГ 23. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН	19

1. ХҮН АМ


Улаанбаатар хотын нийт хүн ам 1 539 810, өрхийн тоо 411 420 болсныг тоолж гаргалаа. Үүнээс гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат иргэн 91.2 мянга байна. Түүнчлэн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат, харьяалалгүй 17.5 мянган иргэд оршин сууж байна. Улаанбаатар хотын нийт хүн амын 48.1 хувь нь эрэгтэйчүүд, 51.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 1. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ТОО



Хүн амын тоо 2020 онд өмнөх 2010 оны тооллогын дүнгээс (1240.0 мянга) 299.8 мянган хүнээр өссөн нь 2000-2010 оны тооллого хоорондын өсөлтөөс 1.6 дахин буурсан байна. Тооллого хоорондын хүн амын тооны өсөлт 1989-2000 онд 211.7 мянган хүн байсан бол 2000-2010 онд 479.9 мянган хүн болж 2.3 дахин нэмэгдэж байжээ. Сүүлийн 10 жилийн хүн амын өсөлтийн бууралтыг агаар орчны бохирдол, нийгмийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлыг харгалзан нийслэлийн Засаг даргын захирамжаар хүн амын шилжилт хөдөлгөөнийг 2017 оноос хязгаарласантай холбон тайлбарлаж болно. Учир нь тухайн үеийн нийслэлийн хүн амын өсөлтийн тавь гаруй хувийг орон нутгаас шилжин ирсэн хүн амын шилжилт хөдөлгөөн буюу механик өсөлт эзэлж байжээ.

ЗУРАГ 2. ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР*



Тайлбар: *Гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо орсон дүнгээр тооцов.

ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ ХҮН АМЫН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР

Тооллого явагдсан он	Хүн амын тоо (мян.хүн)			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
1944	41.0	19.3	21.7	88.9
1956	118.4	62.9	55.5	113.3
1963	223.7	116.5	107.2	108.7
1969	267.4	133.3	134.1	99.4
1979	402.3	198.6	203.7	97.5
1989	548.4	271.2	277.2	97.8
2000	760.1	369.1	391.0	94.4
2010	1 240.0	597.3	642.7	92.9
2020	1 539.8	741.2	798.6	92.8

Хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоог харуулдаг. Улаанбаатар хотын хувьд 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад эрэгтэй, эмэгтэй хүн амын тоо ойролцоо түвшинд байгаа боловч хүйсийн харьцаа 2010 оны тооллогоос ялимгүй буурсан нь харагдаж байна.

Хүснэгтээс харахад 100 эмэгтэйд ногдох эрэгтэй хүн амын тоо 1956, 1963 оны тооллогоор хамгийн өндөр түвшинд байсан бол ялангуяа, 1989 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй буурсаар байна. Үүнд эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, гадаад, дотоод шилжих хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тодруулбал, гадаад руу явж байгаа ажиллах хүчний шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байдаг бол хот руу орон нутгаас суралцахаар ирэгсдийн дийлэнх хувийг эмэгтэйчүүд эзэлдэг ба тэдний ихэнх нь хотод үргэлжлүүлэн суурьшдаг байна. Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн бас нэг гол тулгуур болох уул уурхайн хөгжилтэй уялдан ажиллах хүчний шилжилт явагдан, улмаар орд газруудыг түшиглэн хүн амын төвлөрөл үүсч байгаа ба тэнд ажиллагсдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа нь ч нийслэлийн хүйсийн харьцаа буурахад нөлөөлсөн байж болох юм.


ХҮСНЭГТ 2. ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТ, ХУВИАР 2000-2010, 2010-2020 ОН*

Дүүрэг	Хүн амын тоо (мян.хүн)		2010/2000 (%)	2020/2010 (%)	Жилийн дундаж өсөлт (%)	
	2010	2020			2000-2010	2010-2020
	БҮГД	1 154.3	1 466.1	152.8	127.0	4.8
Багануур	22.4	28.6	106.1	127.5	0.6	3.1
Багахангай	3.4	4.1	96.4	122.6	-0.3	2.5
Баянгол	178.7	225.8	130.0	126.4	2.7	2.9
Баянзүрх	277.5	361.7	188.2	130.3	8.0	3.4
Налайх	30.2	37.6	127.7	124.9	2.5	2.8
Сонгинохайрхан	257.5	327.6	166.9	127.2	6.1	3.0
Сүхбаатар	127.8	144.4	138.6	113.0	3.5	1.4
Хан-Уул	110.3	187.3	154.4	169.8	4.9	7.8
Чингэлтэй	146.5	149.0	140.4	101.7	3.7	0.2

Тайлбар: *Гадаадад б, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат иргэдийн тоо ороогүй дүнгээр тооцов.

Тооллого хооронд Улаанбаатар хотын дүүргүүдийн хүн ам өсөлт харилцан адилгүй байна. Тухайлбал, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн хувьд хүн ам 0.2-1.4 хувь буюу хамгийн бага өсөлттэй байхад Хан-Уул дүүргийн хүн амын өсөлт 7.8 хувь байгаа нь Улаанбаатар хотын дунджаас 2.6 дахин өндөр өсөлттэй байна. Үүнийг сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууцны хорооллууд ихээр баригдсантай холбон тайлбарлаж болно.

ЗУРАГ 3. ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Улаанбаатар хотын хүн ам нь насны бүтцийн хувьд ерөнхийдөө залуу хэвээр байна. Нийт хүн амд 0-14 насны хүүхдийн эзлэх хувийн жин 2010 оны тооллогоос 8.0 пунктээр нэмэгдэж, эсрэгээр хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 8.6 пунктээр буурчээ.

Голч насыг тооцож үзэхэд ерөнхийдөө залуу хандлагатай ба 1989 онд 20.6, 2000 онд 23.5, 2010 онд 25.6, 2020 онд 28.7 байна.

Хүн ам зүйн ачаалал 2020 онд 58.3 болж 2010 оны тооллогоос 19.1 пунктээр өссөн байна. Харин хөгшчүүлийн ачаалал 6.8 болсон нь бага мэт харагдаж байгаа боловч тооллогоос тооллогод тасралтгүй нэмэгдэж өмнөх тооллогоос 1.7 пунктээр нэмэгдсэн байгаа нь цаашид хүн амын насжилт нэмэгдэх, улмаар нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмжийн бодлогын асуудалд анхаарал хандуулж эхлэх хэрэгтэй болсныг илтгэж байна.

2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Монгол Улсын харьяат иргэдийн үндэс, угсааны талаарх мэдээллийг өмнөх тооллогод 29 бүлгээр цуглуулж байсныг Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор 31 болгож өргөжүүлсэн. Тооллогын үр дүнгийн танилцуулгад бүлэгт 100-аас цөөн хүн амтай бүлгийг “Бусад” гэж нэгтгэсэн болно.

Улаанбаатар хотод оршин суугаа Монгол Улсын харьяат 1 448 642 хүн амын 91.2 хувийг Халхууд эзэлж, өмнөх тооллогын үеийнхээс 303 688 хүнээр буюу 0.7 пунктээр өссөн байна. Өнгөрсөн арван жилийн хугацаанд Халхуудаас гадна өсөлт үзүүлсэн угсаатан бол Дарьгангачууд (0.2 пункт) байлаа. Харин Казах, Хотгойд, Буриад, Баяд, Өөлд, Баргуудын нийт

хүн амд эзлэх хувь 0.04-0.4 пунктээр буурсан байна. Ерөнхийдөө Монгол Улсын харьяат хүн амд үндэс, угсаатны эзлэх хувь хоёр тооллогын хооронд маш бага өөрчлөлттэй байсан гэж дүгнэж болно.

ХҮСНЭГТ 3. МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН


Үндэс, угсаа	2010		2020*	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
МОНГОЛ УЛСЫН ХАРЬААТ-БҮГД	1 144 954	100.0	1 448 642	100.0
Халх	1 036 288	90.5	1 321 660	91.2
Казах	9 817	0.9	10 570	0.7
Дөрвөд	22 648	2.0	28 712	2.0
Буриад	17 238	1.5	16 352	1.1
Баяд	18 368	1.6	21 606	1.5
Дарьганга	4 114	0.4	8 046	0.6
Урианхай	6 123	0.5	7 074	0.5
Захчин	8 608	0.8	10 958	0.8
Дархад	1 972	0.2	2 398	0.2
Торгууд	5 706	0.5	6 715	0.5
Өөлд	6 037	0.5	5 660	0.4
Хотон	1 347	0.1	1 608	0.1
Мянгад	1 958	0.2	2 242	0.2
Барга	705	0.1	602	0.0
Хотгойд	1 637	0.1	786	0.1
Сартуул	588	0.1	1 228	0.1
Бусад	1 453	0.1	973	0.1
Бусад үндэстэн (Монголын харьяат гадаад)	347	0.0	1 452	0.1

Тайлбар: *Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

3. ШАШИН

Улаанбаатар хотын 15, түүнээс дээш насны хүн амын 53.7 хувь нь ямар нэгэн шашин шүтдэг, 46.3 хувь нь шашин шүтдэггүй, гэж хариулсан ба 2010 оны тооллогын үетэй харьцуулахад шашин шүтдэг гэж хариулсан хүн амын хувь 7.7 пунктээр буурчээ.

ЗУРАГ 4. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН




Хүйсээр харахад, эрэгтэйчүүдийн шашин шүтдэг гэсэн хариултын хувь өмнөх тооллогоос 6.8, эмэгтэйчүүдийнх 8.7 пунктээр тус тус буурчээ. Шашинтангуудын тоог шүтдэг шашных нь төрлөөр авч үзэхэд 94.6 хувь нь буддын шашин болон бөө мөргөлийг шүтдэг ба 2010 оноос 1.3 пунктээр өссөн байна.

4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Монгол Улсын нийт хүн амын 45.9 хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод, тэр дундаа нийслэл хотын нийт хүн амын 95.2 хувь нь төвийн зургаан дүүрэгт суурьшиж байна.

Монгол Улсын нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь 2010 онтой харьцуулахад 2.3 пунктээр нэмэгджээ. Энэ нь 2000-2010 оны шилжин ирэлт ихтэй он жилүүдээс тав дахин буурсан үзүүлэлт юм.


ЗУРАГ 5. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ХҮН АМД УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Дүүрэг, хороодын нутаг дэвсгэрийн хэмжээ, хот төлөвлөлт, эдийн засгийн хөгжил зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэн нийслэл хотын суурьшил, нягтрал харилцан адилгүй байдаг.

2020 онд нийслэлийн нийт хүн амын 24.0 хувь нь Баянзүрх дүүрэгт, 22.3 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт, нэг үгээр хэлэхэд бараг тал орчим хувь нь энэ хоёр дүүрэгт суурьшиж байна.

ЗУРАГ 6. ХҮН АМЫН НЯГТРАЛ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГЭЭР, 2020 ОН




Дүүргүүдийн нийслэлийн нийт хүн амд эзлэх хувь 2010 онтой харьцуулахад алслагдсан гурван дүүрэг болох Багануур, Багахангай, Налайх дүүргийн нийт хүн амд эзлэх хувь өөрчлөгдөөгүй 10 жилийн хугацаанд хадгалагдан үлджээ. Харин төвийн дүүргүүдийн хувьд өөрчлөлт гарсан байна. Тухайлбал, Хан-Уул дүүрэг бусад дүүргүүдийг бодвол хамгийн их буюу 3.2 пунктээр өссөн бол Сүхбаатар, Чингэлтэй дүүргийнх 1.3-2.5 пунктээр буурсан. Үүнийг сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт орон сууц ихээр баригдаж, Улаанбаатар хотын дүүрэг хоорондын шилжих хөдөлгөөн нэмэгдсэнээр хүн амын суурьшил нэмэгдсэн гэж тайлбарлаж болно. Түүнчлэн дүүргүүдийн хүн амын суурьшил нь газар нутгийн тэлэх боломж, байршил, байгаль орчны нөхцөл байдал зэрэгтэй салшгүй холбоотой байдаг учраас зарим дүүргийн хүн амын тэлэх боломж хязгаарлагдмал байж болох талтай.

5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын товын үед нийслэлийн суурин хүн амын 64.6 хувь нь Улаанбаатар хотод төрөөд, төрснөөсөө хойш шилжих хөдөлгөөнд оролгүй нийслэл хотдоо амьдарч буй уугуул хүмүүс байна. Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 35.4 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад 11.8 пунктээр буурсан байна.


ЗУРАГ 7. ШИЛЖИГЧДИЙН ТОО, ХУГАЦАА, НУТАГ ДЭВСГЭРЭЭР, 2020 ОН



6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш насны хүн амын 95.9 хувь нь ямар нэгэн боловсролын түвшин эзэмшсэн байна. Харин 15, түүнээс дээш насны хүн амын 99.5 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна.

ЗУРАГ 8. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



Тайлбар: * Нийт арав, түүнээс дээш насны хүн амын тоонд Монгол Улсад удаан хугацаагаар амьдарч байгаа гадаад улсын иргэдийг хамруулаагүй болно.

10, түүнээс дээш насны Монголын харьяат суурин хүн амын 36.3 хувь нь дээд ба түүнээс дээш боловсролтой болсон нь 2010 оны үр дүнтэй харьцуулахад 9.2 пунктээр өссөн байна.

7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ


Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн тоо 2010 оноос 36.1 хувиар өссөн байна. Улаанбаатар хотын хэмжээнд 411.4 мянган өрх тоологдсоноос 52.4 хувь нь ам бүлээрээ байгаа өрх, 28.9 хувь нь нийлмэл ам бүлтэй, 14.6 хувь нь ганц бие, 4.1 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

ХҮСНЭГТ 4. ӨРХИЙН ТОО, ДҮҮРЭГ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Дүүрэг	2010		2020		2020 2010 %
	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	өрхийн тоо	дүнд эзлэх хувь	
БҮГД	302 242	100.0	411 420	100.0	136.1
Багануур	6 430	2.1	8 133	2.0	126.5
Багахангай	952	0.3	1 131	0.3	118.8
Баянгол	47 507	15.7	62 976	15.3	132.6
Баянзүрх	73 376	24.3	104 764	25.5	142.8
Налайх	8 093	2.7	10 248	2.5	126.6
Сонгинохайрхан	65 866	21.8	93 521	22.7	142.0
Сүхбаатар	33 513	11.1	40 061	9.7	119.5
Хан-Уул	28 782	9.5	51 241	12.5	178.0
Чингэлтэй	37 723	12.5	39 345	9.6	104.3

Улаанбаатар хотын өрхийн тоо 2010 оныхоос 109.2 мянган (36.1%) өрхөөр өссөний дотор Хан-Уул дүүргийн өрхийн тоо 78.0 хувь, Баянзүрх дүүргийн өрхийн тоо 42.8 хувиар өссөн байна.

ЗУРАГ 9. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Нийслэлд өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 болсон нь 2010 оны ам бүлийн дундаж тооноос 0.1 пунктээр буурчээ. Харин 1-2 ам бүлтэй өрхийн эзлэх хувь ихээхэн өөрчлөгдсөн нь шилжих хөдөлгөөн өөрөөр хэлбэл, хотод их, дээд сургуульд суралцагчид, болон ажил хөдөлмөр хийхээр шилжин ирсэн хүмүүс тусдаа өрх болж тоологдсонтой холбоотой байж болох юм.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Улаанбаатар хотын арван тав ба түүнээс дээш насны нийт хүн амын дотор гэр бүлтэй хүн амын эзлэх хувь 61.4 болж 2010 оныхоос 4.7 пунктээр өсжээ.


Арван тав, түүнээс дээш насны хүн амын 34.3 хувийг огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүд эзэлж байхад, эмэгтэйчүүд 28.0 хувийг буюу 6.3 пунктээр бага байна. Энэ зөрүү 2010 онд 0.7 пункт байсан бол энэ удаагийн тооллогоор 9 дахин нэмэгджээ. Үүнийг нэг талаас эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол харьцангуй залуудаа нөхөрт гардаг, нөгөө талаас гадаадад ажил эрхлэхээр явж байгаа хүмүүсийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр, түүнчлэн уул уурхайн хөгжлийг дагаад эрэгтэйчүүд олон сараар хөдөө орон нутагт суурьшиж ажилладаг гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогын дүнгээр улсын дунджаар эмэгтэйчүүд 26.7 насандаа, нийслэлд 27.2 насандаа, эрэгтэйчүүд 28.6 насандаа, нийслэлд 28.5 насандаа анх гэр бүл болж байна.


8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Улсын хэмжээнд 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор хөгжлийн бэрхшээлтэй 106.4 мянган хүн байгаа нь хүн амын 3.3 хувийг эзлэж, 2010 оноос 0.8 пунктээр буурсан байна. Үүнээс 36.7 мянга буюу 34.5 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Нийслэл хотын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 36.7 мянган хүн байгаа нь суурин хүн амын 2.5 хувийг эзэлж байна. Энэ нь улсын дундажтай харьцуулахад 0.9 пунктээр бага үзүүлэлттэй юм. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүний 20.2 мянга буюу 55.1 хувь нь эрэгтэй, 16.5 мянга буюу 44.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 10. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН




ЗУРАГ 11. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ДҮҮРГЭЭР, НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



Монгол Улсад оршин суугаа хүн амын бараг хоёр хүн тутмын нэг нь, ойролцоогоор хөгжлийн бэрхшээлтэй гурван иргэн тутмын нэг нь Улаанбаатар хотод амьдарч байна. Гэхдээ дүүргүүдээр авч үзэхэд харилцан адилгүй байна. Тухайлбал, нийслэл хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 44.3 хувь нь Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт ногдож байна. Мэдээж энэ нь тухайн дүүргүүдэд хүн амын тоо харьцангуй өндөр байдагтай холбоотой юм. Дүүргүүдийг харьцуулан дүгнэх үүднээс тухайн дүүргийн хүн амд эзлэх хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийг гаргаж үзэхэд Багануур (3.8%), Багахангай (4.1%), Налайх (4.2%), Чингэлтэй (3.0%) дүүргүүд нийслэлийн дунджаас 0.5-1.7 пунктээр өндөр байна.

ЗУРАГ 12. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Хөгжлийн бэрхшээлтэй хүний нас, хүйсийн суваргаас харахад 15-19 насны бүлгээс дээш 55-59 насны бүлэг хүртэл, нас ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо аль ч хүйсэнд өсч байснаа 60, түүнээс дээш насанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо огцом буурч байна. Энэ нь нас баралттай холбоотой. Мөн 54-69 насны хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүн амын тоо эмэгтэйчүүдээс илүү байгаа нь ажиглагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хувийг 2010 онтой харьцуулахад 10-19 нас, 20-29 нас, 40-49 насны бүлэгт буурчээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 36.7 мянган хүний 18.3 мянга буюу 49.9 хувь нь төрөлхийн, үлдсэн 18.4 мянга буюу 50.1 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна.

Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүний 11.4 хувь буюу 4.2 мянган хүн харааны, 3.0 хувь буюу 1.1 мянган хүн ярианы, 8.6 хувь буюу 3.1 мянган хүн сонсголын, 20.9 хувь буюу 7.7 мянган хүн хөдөлгөөний, 19.9 хувь буюу 7.3 мянган хүн сэтгэцийн, 6.4 хувь буюу 2.4 мянган хүн хавсарсан, 29.8 хувь буюу 10.9 мянган хүн “Бусад” төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөлд ихээхэн өөрчлөлт оржээ. Тодруулбал, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эзлэх хувь 2010 оноос 21.6 пунктээр өссөн бол эсрэгээр мөн тийм хэмжээгээр олдмол хөгжлийн бэрхшээл буурсан аж. Үүнд агаар, хөрсний бохирдол, хүнсний бүтээгдэхүүний чанар, иргэдийн эрүүл мэнд гэх мэт олон хүчин зүйл нөлөөлсөн нь лавтай. Иймээс цаашид үүсээд буй нөхцөл байдлыг гүнзгийрүүлэн судалж, баталгаажуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

ЗУРАГ 13. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020




Нийслэлийн нутаг дэвсгэрт оршин суух үйлдлийн чадварын хүндрэлтэй нийт иргэдийн 45.6 хувь нь эрэгтэй, 54.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Насны бүлгээр авч үзэхэд 20-24 насны үйлдлийн чадварын хүндрэлтэй хүмүүсийн хамгийн их хүндрэл нь харааны хүндрэл байгаа бол 35-54 насныхны хувьд алхах, харин 55 түүнээс насныхны хувьд харааны болон алхах хүндрэлүүд байна.

9.ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Улаанбаатар хотын 6, түүнээс дээш насны хүн амын 91.2 хувь буюу 1136.6 мянган иргэн гар утас хэрэглэж байгаа ба 2010 оны тооллогын үеэс 251.8 мянга хүнээр буюу 28.5 хувиар нэмэгджээ. Гар утас хэрэглэгчдийн 46.5 хувийг эрэгтэй, 53.5 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.

ЗУРАГ 14. НИЙСЛЭЛИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, ДҮҮРГЭЭР



ЗУРАГ 15. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН




9.ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН

Дэлхий нийтээр даяаршиж интернэтийн хэрэглээ маш хурдан өссөөр байгаа ба Монгол Улсад ч бас 3G болон 4G сүлжээ орж ирснээр гар утас болон интернэт хэрэглэгчдийн тоо ихэссэн байна.

Улаанбаатар хотод 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор 6, түүнээс дээш насны нийт хүн амын 76.0 хувь буюу 946.7 мянган хүн интернэт хэрэглэж байгаа бөгөөд интернэт хэрэглэгчдийн хувь 2010 оноос 26.7 пунктээр өсчээ. Эдгээрийн 47.4 хувь нь эрэгтэй, 52.6 хувь нь эмэгтэйчүүд байв.

ЗУРАГ 16. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2010, 2020 ОН




10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Улаанбаатар хотод арван тав, түүнээс дээш насны хүн амын 59.3 хувь буюу 587.2 мянган хүн ажиллах хүчинд багтаж байгаагийн дотор 85.4 хувь нь ажил эрхлэгчид, 14.5 хувь ажил хайж буй хүн ам эзлэж байна. Ажиллах хүчний оролцооны түвшнийг 2010 оны үетэй харьцуулахад 7.4 пункт, ажил эрхлэгчид 5.8 пункт, ажил хайж буй хүн ам 1.6 пунктээр тус тус өссөн байна.

Нийт хөдөлмөрийн насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 6.0 пунктээр нэмэгдэж, ажиллах хүчнээс гадуурх хүн амын хувийн жин 3.3 пунктээр буурч, ажилгүй иргэд 5.9 хувийг эзэлж байна. 60, түүнээс дээш насны хүн амын 12.4 хувь нь ажиллах хүчинд хамрагдаж байгаа ч өмнөх тооллогын үеийнхээс тухайн насны хүн амын ажиллах хүчинд эзлэх хувь 6.0 пунктээр нэмэгдсэн нь эерэг үзүүлэлт байна.

ЗУРАГ 17. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН



Ажил эрхэлдэг хүн амын тоо 502.0 мянга болж 2010 оноос 110.5 мянган хүнээр буюу 28.2 хувиар өссөн нь эерэг үр дүн байлаа. Хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хувь өмнөх тооллогоос 6.9 пунктээр өссөн байна.

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 50.7 хувь нь ажил эрхэлж байгаа нь улсын дунджаас 3.1 пунктээр доогуур байна. Энэ нь *нэгдүгээрт*, нийслэлд их, дээд сургууль олноор төвлөрч, суралцагчдын тоо байнга нэмэгдэж байгаа, *хоёрдугаарт*, хүн ам хэт төвлөрснөөс үүдэн ажлын байрны олдоц ховор байгаа, *гуравдугаарт*, хэдийгээр сүүлийн гурван жилд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгалыг тодорхой хэмжээгээр хязгаарласан боловч өмнөх он жилүүдэд шилжин ирэгсэдийн тоо өндөр байсан зэрэгтэй холбоотой.


Улаанбаатар хотын хүн ам улсын хүн амын 45.9 хувийг эзлэж, хувийн жин нь жилээс жилд нэмэгдэж байгаа боловч ажил эрхэлдэг хүний хувийн жин хүн амын өсөлтөө даган төдийлэн хурдацтай нэмэгдэж чадахгүй байна.

Улаанбаатар хотод ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 402.2 мянга байгаа нь өмнөх тооллогоос 4.1 хувиар буурчээ. Эдгээрийн 41.1 хувь нь эрэгтэй, 58.9 хувь нь эрэгтэй байв. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын шалтгааныг 2010 онтой харьцуулахад тэтгэвэрт гарсан хүний тоо 31.0 хувь, бусад шалтгаанаар ажил эрхлээгүй хүн 24.2 хувь, ажиллах сонирхолгүй хүний тоо 4.6 хувиар өссөнөөс бусад шалтгаан бүгд буурсан аж.

ХҮСНЭГТ 5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, ДҮҮРЭГ, ХҮЙС, ХУВИАР, 2020 ОН

Дүүрэг	Ажиллах хүчний оролцооны түвшин			Ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	59.3	64.6	54.7	40.7	35.4	45.3
Багануур	56.3	61.5	51.4	43.7	38.5	48.6
Багахангай	56.0	59.6	52.3	44.0	40.4	47.7
Баянгол	62.6	67.0	58.9	37.4	33.0	41.1
Баянзүрх	60.9	65.9	56.5	39.1	34.1	43.5
Налайх	51.0	57.0	45.4	49.0	43.0	54.6
Сонгинохайрхан	58.9	65.4	52.8	41.1	34.6	47.2
Сүхбаатар	56.7	61.5	52.5	43.3	38.5	47.5
Хан-Уул	62.1	66.7	58.2	37.9	33.3	41.8
Чингэлтэй	53.7	59.0	48.8	46.3	41.0	51.2

ЗУРАГ 18. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, ДҮҮРГЭЭР, 2020 ОН



Улаанбаатар хотын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2020 онд 14.5 болж, өмнөх тооллогын үеийнхээс 1.1 пунктээр өсч, улсын дүнгээс 4.6 пунктээр дээгүүр байна.(Улсын дүн 9.9 хувь байна).

11. ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД


Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 91 168 иргэн тоологдож 2010 оноос 6.3 хувиар өсжээ.

ЗУРАГ 19. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ХҮН АМЫН ТОО, УЛСААР




Гадаадад тоологдсон иргэдийн 2 хүний 1 нь буюу 53.1 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 4 хүн тутмын 1 нь Европ тивд суугаагаар тоологдсон байна.

ЗУРАГ 20. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН ДҮҮРГЭЭР, 2020 ОН



Тооллогын үед гадаадад оршин суугаа хүмүүсийн 35.8 хувь нь суралцахаар, 11.5 хувь нь суурьшихаар, 10.0 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 1.1 хувь нь албан томилолтоор, 18.5 хувь нь ажиллахаар, 13.1 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 10.0 хувь нь бусад шалтгаанаар гадаадад оршин сууж байна.


ЗУРАГ 21. ГАДААДАД ОРШИН СУУГАА НИЙСЛЭЛИЙН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2020 ОН



12. СУУЦНЫ НӨХЦӨЛ

Монгол Улсын нийт өрхийн 45.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхтэй харьцуулахад 2.2 пунктээр илүү байна. Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийслэл Улаанбаатар хотод 411.4 мянган өрх амьдарч байгаагийн 22.2 хувь нь монгол ард түмний уламжлалт сууц гэрт, 77.3 хувь нь байшинд, 0.5 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

ЗУРАГ 22. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 6.8 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 7.7 пунктээр нэмэгджээ.

Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг 141.7 мянган сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 387.8 мянган сууц тоологдсон.

ХҮСНЭГТ 6. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019, 2020 ОН

Сууцны төрөл	Хүн байнга амьдардаг сууц		Өрхийн тоо	
	Сууцны тоо	Дүнд эзлэх хувь	мян.өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	387.8	100	411.4	100.0
Гэр	58.0	15.0	91.2	22.2
Байшин	329.8	85.0	317.9	77.3
Бусад сууц	-		2.2	0.5

Тооллогоор хүн байнга амьдардаг сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухайн сууцанд амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 41.0 хувь нь гэр сууц, 54.9 хувь нь сууцны тусдаа байшин, 2.9 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин, 0.6 хувь нь бие даасан тохилог сууц, 0.6 хувь нь нийтийн байр тоологдсон байна. Нийтийн зориулалттай 4 077 орон сууцны байшинд 250 221 сууц тоологдсон байна.

ЗУРАГ 23. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН

